

АНХААРАХ:
Тухайн төлбөрийн баримтыг малчин баталгаажуулалт хийх шаардлагатай.


ТӨЛБӨРИЙН БАРИМТЫГ ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛАХ ВЭ?

Үйлдвэрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч үүсгэсэн төлбөрийн баримтыг малчид баталгаажуулалт хийх шаардлагатай. Ингэснээр та өөрийн борлуулалтын хэмжээнд хяналт тавих болон урамшууллын дүнг мэдэх боломжтой юм. Баталгаажуулалтыг гар утасны ebarimt аппликейшн болон компьютероор хандалт хийж баталгаажуулах боломжтой.

ГАР УТАСНЫ ЕВАРИМТ АППЛИКЕЙШНЭЭР БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ






Өөрийн ebarimt аппликейшн рүү хандалт хийж нэвтэрч орсны дараа Татвар цэсийг дарна. Татвар цэсийн хамгийн сүүлийн хуудас буюу **Төлбөрийн баримт** гэсэн хуудсыг гараараа гүйлгэж гаргана.



Баруун тийш гүйлгэж хамгийн сүүлийн хуудсан дээр аваачих шаардлагатай.

Тухайн хийгдсэн төлбөрийн баримтыг баталгаажуулах болон цуцлах боломжтой. Тухайн төлбөрийн баримт дээр дарахад **БАТАЛГААЖУУЛАХ** болон **ЦУЦЛАХ** товч гарах бөгөөд тухайн аль нэг үйлдлийг хийхэд зурагт үзүүлсэнтэй ижил анхааруулга өгнө.





ГАРАХ ҮР ДҮН:

Төлбөрийн баримт амжилттай үүссэн талаарх анхааруулга буюу мэдэгдэл өгнө.




**ЕВАРИМТ-ИЙН НЭВТРЭХ НЭР БОЛОН
НУУЦ ҮГИЙГ АШИГЛАЖ
КОМПЬЮТЕР ЛҮҮ ХАНДАЛТ ХИЙН
БАТАЛГААЖУУЛАХ**

АЛХАМ


1

Цахим төлбөрийн баримтын систем /ebarimt/-д “**Бизнес эрхлэгч**”-ээр хандалт хийж орно. Үүний тулд регистрийн дугаарыг 2 удаа оруулан, нууц үг хийж **Нэвтрэх** товч дарах шаардлагатай. Та өөрийн нэвтрэх нэр болон нууц үгийг харьяа татварын албанаас авах боломжтой.







АЛХАМ

2

Цахим төлбөрийн баримтын системд нэвтэрч орсны дараа **ТӨЛБӨРИЙН БАРИМТУУД** талбарын **ebarimt-p** хийгдсэн баримтын жагсаалт хэсгээс байгууллага хооронд хийгдсэн баримт буюу  товч дээр дарж, он сар болон борлуулалт гэсэн төлвийг сонгож **ХАРАХ** товч дарна.

ЕВАРИМТ-Р ХИЙГДСЭН БАРИМТЫН ЖАГСААЛТ

  ТТД: ТТД Жил: 2020 Сар: 11 Борлуулалт  

Баримт Засагдсан баримт Зөрчилтэй баримт Баталгаажаагүй буцаалт **Баталгаажаагүй баримт** Шалгах баримт(Өндөр дүнтэй)

Хилийн гадна

№	ДТД	Огноо	Баримт шивсэн хэрэглэгч	Харилцагч	НӨАТ	Нийт дүн	Төлөв
1	23199104209600020112900001882848	2020-11-29			49.27₮	542.00₮	Баталгаажаагүй баримт

АЛХАМ

3

Гарч ирсэн дэд цэсээс **БАТАЛГААЖААГҮЙ БАРИМТ**-ыг сонгож, үнийн дүнгээ дарахад **БАТАЛГААЖУУЛАХ** болон **ЦУЦЛАХ** товч гарах бөгөөд тухайн аль нэг үйлдлийг хийхэд **анхааруулга** өгнө.

№	ДТД	Огноо	Баримт шивсэн хэрэглэгч	Харилцагч	НӨАТ	Нийт дүн	Төлөв
1	23199104209600020112900001882848	2020-11-29			49.27₮	542.00₮	Баталгаажаагүй баримт
2	23199104209600020112800001882848	2020-11-29			709.09₮	7,800.00₮	Баталгаажаагүй баримт
3	23199104209600020112800001882848	2020-11-29			60.55₮	666.00₮	Баталгаажаагүй баримт
4	23199104209600020112800001882848	2020-11-29			45.64₮	502.00₮	Баталгаажаагүй баримт

Үйлдэл

Баталгаажуулах

Цуцлах

Хаах